

**“Тавантолгой төмөр зам” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК-д
төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн тухай**

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө батлах тухай”-д заасны дагуу санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын үр нөлөө болон бусад үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн хугацаа

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Гурав. Хяналт шалгалтад хамрагдсан асуудал

Шалгалтад дараах асуудлуудыг хамруулсан. Үүнд:

1. Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилт;
2. Цалин хөлс тогтоолт, бодолт, олголт;
3. Шатах тослох материалын төлөвлөлт зарцуулалт;
4. Гадаад, дотоод томилолт олгохтой холбоотой дүрэм, журмын хэрэгжилт, үр дүн;
5. Тухайн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлт;
6. Бусад

Дөрөв. Хяналт шалгалтаар тогтоогдсон бодит нөхцөл байдал

Хяналт, шалгалтын явцад нийт 7 зөрчил, дутагдал илэрсэн бөгөөд эдгээрийг арилгуулах зорилгоор 5 заалт бүхий улсын ахлах байцаагчийн 2 акт үйлдэн, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад тодорхой үүрэг, даалгавар өгч ажиллалаа.

Тав. Хяналт шалгалтын явцад авсан арга хэмжээ, зөвлөмж

Дээр дурдсан илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаатай үүрэг, даалгавар өгсөн.

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР